ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 240

танай _____ -ны № _____ -т

ТОНХИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитын шийдвэрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

Хавсралт .. хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

07030645

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говь Алтай аймгийн Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/10/-НА-СТА-ТТЗ

Дарга,Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 70484030 Цахим хаяг: tserednkhandd@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ 3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ 5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/ 10
3. Аудитын тайлан 11
3.1. Ерөнхий зүйл 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 12
3.4 Материаллаг байдал 12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт 12
3.5.1 Орлогын данс 13
3.5.2 Зардлын данс 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 14
3.8 Аудитын гол асуудал 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
4. Аудитын илрүүлэлт 16
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 19
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 175

танай_____ -ны №_____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ТОНХИЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.НАСАНБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020468

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болович материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	889,704.1	1,291,257.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	346,393.2	483,672.7
33	АВЛАГА	148,321.9	244,925.8
35	БАРАА МАТЕРИАЛ	328,533.4	372,641.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	65,350.8	190,017.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,921,890.9	2,793,980.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,921,890.9	2,793,980.9
39200	Биет хөрөнгө	2,801,835.9	2,675,089.0
39300	Биет бус хөрөнгө	120,055.0	118,891.9
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**3,811,595.0**	**4,085,238.5**
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,000.0	6,604.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,000.0	6,604.0
41300	Өглөг	2,000.0	6,604.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,809,595.0	4,078,634.5
51	Засгийн газрын хувь оролцоо	3,809,595.0	4,078,634.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,841,937.6	1,841,937.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,057,802.7	1,326,842.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	909,854.8	909,854.8
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**3,811,595.0**	**4,085,238.5**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	3,205,488.2	2,994,252.4
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	114,320.9	213,486.2
110	**Орлогын албан татвар**	98,373.7	123,099.7
1100	**Хувь хүний орлогын албан татвар**	98,373.7	123,099.7
113	**Хөрөнгийн албан татвар**	4,600.0	76,173.9
118	**Бусад татвар, төлбөр, хураамж**	11,347.2	14,212.6
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	135,304.6	224,341.6
120	**Нийтлэг татварын бус орлого**	135,304.6	224,341.6
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	2,955,862.6	2,556,424.6
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	3,289,035.5	2,714,940.5
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	3,289,035.5	2,714,940.5
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	2,457,736.1	2,607,441.8
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	1,532,113.9	1,574,122.1
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	195,502.4	210,337.7
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	90,720.5	113,060.0

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2104	Хангамж, бараа материалын зардал	62,528.0	72,690.8
2105	Нормативт зардал	56,974.3	183,245.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,298.5	41,332.0
2107	Томилолт, зочны зардал	3,374.0	1,487.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,755.5	11,252.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	472,469.0	399,915.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	831,299.4	107,498.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-83,547.3	279,311.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	185,870.8	10,272.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-269,418.1	269,039.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,216,350.0	2,756,038.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	114,320.9	213,486.2
110	Орлогын албан татвар	98,373.7	123,099.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	98,373.7	123,099.7
113	Хөрөнгийн албан татвар	4,600.0	76,173.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	11,347.2	14,212.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,115.9	4,628.8
1181	Газрын төлбөр	7,231.4	2,189.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	7,394.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,226.5	76,378.0
120	Нийтлэг татварын бус орлого	140,226.5	76,378.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,961,802.6	2,466,174.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,941,216.0	2,315,823.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,941,216.0	2,315,823.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,050,396.6	2,208,324.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,532,113.9	1,574,162.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,502.4	210,430.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,105.0	108,521.2
2104	Хангамж, бараа материалын зардал	53,658.7	63,556.7
2105	Нормативт зардал	48,073.4	130,071.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000.0	46,855.2
2107	Томилолт, зочны зардал	3,374.0	1,487.1

2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	31,755.5	11,250.0
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	74,813.7	61,990.4
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	890,819.4	107,498.7
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	275,134.0	440,215.8
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	147,179.7	248,936.3
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	147,179.7	248,936.3
2200	**Дотоод эх үүсвэрээр**	147,179.7	248,936.3
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	-147,179.7	-248,936.3
VII	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**	-103,000.0	-54,000.0
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	103,000.0	54,000.0
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	24,954.3	137,279.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	321,438.9	346,393.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	346,393.2	483,672.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	4,092,513.1	4,092,513.1
2	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**	-13,500.0	-13,500.0
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	4,079,013.1	4,079,013.1
4	**Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт**	0.0	0.0
5	**Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт**	0.0	0.0
6	**Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз**	0.0	0.0
7	**Өмчид гарсан өөрчлөлт**	0.0	0.0
8	**Зарласан ногдол ашиг**	0.0	0.0
9	**Тайлант үеийн үр дүн**	-269,418.1	-269,418.1
10	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	3,809,595.0	3,809,595.0
11	**2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	3,809,595.0	3,809,595.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	3,809,595.0	3,809,595.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	269,039.5	269,039.5

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

20	**2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	4,078,634.5	4,078,634.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**2,768,772.10**	**2,448,313.44**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**2,369,308.60**	**2,249,374.40**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**2,326,849.80**	**2,208,390.54**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	1,606,910.40	1,560,592.98
210101	Үндсэн цалин	1,257,620.20	1,238,549.93
210102	Нэмэгдэл	129,398.40	125,687.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,000.00	4,365.00
210104	Урамшуулал	81,306.20	78,320.29
210105	Гэрээт ажлын хөлс	132,585.60	113,670.45
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	225,374.50	208,958.65
210201	Тэтгэврийн даатгал	159,792.70	147,033.17
210202	Тэтгэмжийн даатгал	16,262.90	15,402.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,248.20	12,574.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,279.30	3,026.10
210205	Эрүүл мэндийн даатгал	32,791.40	30,922.09
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	126,525.40	108,521.15
210301	Гэрэл, цахилгаан	21,950.00	10,473.95
210302	Түлш, халаалт	104,395.40	98,047.20
210303	Цэвэр, бохир ус	180.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	70,373.30	60,709.73
210401	Бичиг хэрэг	7,550.20	6,225.54
210402	Тээвэр, шатахуун	50,838.80	44,334.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,492.80	2,184.30
210404	Ном, хэвлэл	760.00	604.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,390.80	1,105.35
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,340.70	6,255.85
2105	**Норматив зардал**	87,161.70	80,801.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,342.00	14,608.88
210502	Хоол, хүнс	45,589.70	43,361.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,230.00	22,830.90
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	132,475.70	130,214.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,795.70	57,112.20
210602	Тавилга	37,000.00	36,866.78
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	880.00	872.75
210604	Урсгал засвар	35,800.00	35,362.50
2107	**Томилолт, зочны зардал**	5,862.10	420.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,862.10	420.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	8,558.00	4,503.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,110.00	1,403.15
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,078.00	648.00
210803	Даатгалын үйлчилгээ	550.00	369.45
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	620.00	560.00
210807	Газрын төлбөр	750.00	750.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.00	665.73
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200.00	85.25
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	63,608.70	53,668.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,062.50	46,697.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,546.20	6,971.40
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	42,458.80	40,983.85
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	42,458.80	40,983.85
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,840.10	26,851.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,618.70	14,132.55
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	247,965.90	144,939.05
220001	Барилга байгууламж	0.00	0.00
221001	Их засвар	0.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө	247,965.90	144,939.05
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0.00	0.00
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	151,497.60	54,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	151,497.60	54,000.00
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**2,768,772.10**	**2,487,077.33**
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**1,664,809.70**	**1,627,588.03**
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,664,809.70	1,627,588.03
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**830,546.90**	**781,636.27**
320001	Орон нутгийн төсвөөс	681,196.00	632,285.37
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	149,350.90	149,350.90
33	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**22,072.90**	**5,040.55**
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,072.90	5,040.55
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**251,342.60**	**72,812.48**
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,626.60	69,192.48
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,253.60	3,620.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	157,462.40	0.00
37	**БУСАД ЭХ ҮҮСВЭР**	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	169,592.44

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	208,356.33

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	133,999.14
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	133,999.14
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	103,931.08
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	13,569.08
210101	Үндсэн цалин	6,566.97
210104	Урамшуулал	7,002.11
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	1,471.63
210201	Тэтгэврийн даатгал	1,471.63
2104	**Хангамж, бараа материалын зардал**	3,247.00
210401	Бичиг хэрэг	200.00
210402	Тээвэр, шатахуун	2,987.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60.00
2105	**Норматив зардал**	49,269.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,877.35
210502	Хоол, хүнс	1,392.50
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	19,409.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,509.30
210604	Урсгал засвар	5,900.00
2107	**Томилолт, зочны зардал**	1,067.06
210702	Дотоод албан томилолт	1,067.06
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	6,886.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,471.11
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,415.35
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	9,010.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,180.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	830.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	30,068.07
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	29,184.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,184.00
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**	884.07
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	109.19
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	774.87
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	186,889.86
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	186,889.86
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,078.76
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,581.10
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	128,230.00
III	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**	52,890.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,890.72

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээд Сумын Засаг даргад гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй холбоотой, түүвэрт хамрагдсан Соёлын төв, ИТХ-д Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах гэсэн эрхэм зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 2,614.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 52.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 41.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 2,827.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 56.5 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7 хувиар буюу 273.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 483.7 сая төгрөг болж 137.3 сая төгрөгөөр өссөн нь СХС-гийн авлага барагдан орж ирсэн, ОНХС-гийн төлөвлөсөн ажлууд хийгдээгүйтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 244.9 сая төгрөг болж 96.6 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ-ийн ЭМДСангаас авах авлага 90.2 сая төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 372.6 сая төгрөг болж 44.1 сая төгрөгөөр өссөн нь ковид цар тахалтай холбоотойгоор ЭМТ дээр эм боох материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 347.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 107.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 400.2 сая төгрөгийн материалыг зарцуулж, 3.7 сая төгрөгийн материалыг шилжүүлжээ. Оны эцэст 372.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,793.9 сая төгрөг болж 127.9 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Тайлант онд акталж устгасан, шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 6.6 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ дээр 4.6 сая төгрөгийн санхүүжилт илүү өгснийг өглөгөөр тусгасан байна. Он дамнасан 2.0 сая төгрөгийн өглөг ОНХС дээр бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,078.6 сая төгрөг болж 269.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 7 хувиар буюу 211.2 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого буурсантай холбоотой байна

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,326.8 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 213.5 сая төгрөгийн татварын орлого, 224.3 сая төгрөгийн татварын бус орлого, 2,556.4 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,994.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,714.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 10.3 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тонхил сумын ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 30-ны "Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай" 02 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 84.2 сая төгрөгийн татварын 1.2 сая төгрөгийн татварын бус нийт 85.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 217.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 254 хувиар биелүүлсэн байна. Сумын ОНО-ын төлөвлөлтийг тодотгож батлуулаагүйгээс 254 хувиар төлөвлөгөө давж биелсэн харагдаж байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс азрын төлбөрийн орлого 0.7 сая төгрөгөөр, шууд бус орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Говь Алтай аймгийн Тонхил сумын төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг нэгтгэн гараагүй байна.

Сумын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2,746.0 сая төгрөгийг сумын төсвөөс 2021 оны төсвийн жилд зарцуулахаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан төгрөгийн төсөв батлагдсанаас 2,369.3 сая төгрөгийг урсгал зардалд, 247.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 151.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,664.8 сая төгрөгийг улсын төсвөөс буюу тусгай зориулалтын шилжүүлгээс, 830.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 251.3 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 22.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан. Харин орон нутгийн ЭМТ-д 4.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү өгснийг авлагаар тусгасан, ЭМДСангаас 17.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус дутуу авсан байна. СХС-гийн орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 37.5 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 72.8 сая төгрөг бүрдүүлж 178.5 сая төгрөгөөр тасарсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 98.0 сая төгрөг, СХС-гийн 58.8 сая төгрөгийг олгоогүй нь зарцуулалт гараагүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,448.3 сая төгрөг буюу 88 хувьтай байгаа нь зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.
Тайлант онд

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 4.0 сая төгрөг
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 52.0 сая төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2.6 сая төгрөг
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 128.2 сая төгрөг нийт 186.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшилд 13.6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 3.3 сая төгрөг, норматив зардалд 49.3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 19.4 сая төгрөг, томилолтын зардалд 1.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 6.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 9.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 30.0 сая төгрөг нийт 133.9 сая төгрөгийг зарцуулж, ЭМТ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 52.89 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 36 мэдээллийг "Тонхил сумын Засаг дарга" цэсэд ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тонхил сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 6.1 сая төгрөгийн 21 мэдээллээс 6.1 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тонхил сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 8.9 сая төгрөгийн 22 мэдээллээс, 8.9 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тонхил сумын Алтансоёмбо ЕБС нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 20 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тонхил сумын Алтансоёмбо ЕБС нь тайлант онд 0.6 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү шивүүлснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалтуудтай заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.5 сая төгрөгийн 5 заалт албан шаардлага, 8.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн бөгөөд албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан бөгөөд зөвлөмж хэрэгжилтийн шатандаа байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Өмнөх 2020 оны СТА-аар сумын ИТХ-д 1 заалт албан шаардлага, Соёлын төвд 1 заалт албан шаардлага, ОНХС-гийн санхүүгийн тайлангийн түүврийн аудитаар 2 заалт албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийцлийн аудитын тухайд:

Өмнөх 2018 оны НА-аар Тонхил сумын ОНХС-гийн аудитаар "Өндөр Индэр" хоршоотой байгуулсан гэрээний хугацаа дуусан байхад 4.0 сая төгрөгийн өвс тэжээлийн мөнгийг төлүүлээгүй бөгөөд гэрээний дагуу 2.0 сая төгрөгийн алданги нэмж ногдуулан нийт 6.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. Үлдэгдэл 2.0 сая төгрөгийн төлбөрийн актыг төлөөгүй ба мэдэгдэл хүргүүлсэн байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа ТТЗ-ийн аудитаар орон нутгийн орлого, татварын тодорхойлолт, өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Дараа жилийн түүвэрт хамрагдах нэгж байгууллагын аудитаар цалин, бараа материалын тайлангийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 төсөл сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 3 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" 5 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 371.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 214.7 сая төгрөгийн алдааг залруулж, 18.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 138.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийг залруулж, 15.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:
Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:
Алтансоёмбо багийн ЕБС нь тайлант онд 681.9 мянган төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү шивүүлснийг аудитын явцад залруулаа.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлан - Төлбөрийн акт тогтоогоогүй.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Түүвэрт хамрагдсан байгууллага - Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

- Газрын төлбөрийн орлого 0.7 сая төгрөгөөр, шууд бус орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:
Тонхил сумын ИТХ

- Татварын тодорхойлолтоор 0.07 сая төгрөгийн дутуу, 4.6 сая төгрөгийн төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Төсвийн хэмнэлтийн горим зөрчин 6.1 сая төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.4-д " энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тонхил сумын Соёлын төв

- Татварын тодорхойлолтоор 0.6 сая төгрөгийн илүү, 1.2 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,

баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Төсвийн хэмнэлтийн горим зөрчин 0.5 сая төгрөгийн ажлын хувцас худалдан авсан Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тонхил сумын Алтансоёмбо ЕБС

- Татварын тодорхойлолтоор 1.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Соёлын төв, Цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй зөрчлийг арилгах зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Сумын Засаг даргад

1.1 Илрүүлэлт: Сумын ИТХ, Цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлаагүй, ИТХ, Алтансоёмбо багийн ЕБС, цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д ".өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тонхил сумын ИТХ-д

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 6.1 сая төгрөгийн 21 мэдээллээс 6.1 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлж ажиллах

Тонхил сумын Соёлын төвд

2.3 Илрүүлэлт: Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 8.9 сая төгрөгийн 22 мэдээллээс, 8.9 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

2.4 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
ТТЗ											
Тонхил сумын ТТЗ		2	1.0					1	1.0	1	0
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв		3	2.2			0	0	3	2.2	0	0
ИТХ		3	10.8			0	0	3	10.8	0	0
Алтансоёмбо ЕБС		3	1.9	1	0.7			2	1.2	0	**0**
Дүн		**11**	**15.9**	**1**	**0.7**	**0**	**0**	**9**	**15.2**	**1**	**0**
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
ТТЗ		0	0			0	0	0	0	0	0
Дүн		**0**	**0**			**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**
Соёлын төв		1	0			0	0	0	0	1	0
ИТХ		1	0			0	0	0	0	1	0
Дүн		**2**	**0**			**0**	**0**	**0**	**0**	**2**	**0**
Нийт дүн		**13**	**15.9**	**1**	**0.7**	**0**	**0**	**9**	**15.2**	**3**	**0**